# БАГАНУУР ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 01 сарын 02 өдөр　　　Дугаар А/01　　　Улаанбаатар хот

**Дүүргийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг батлах тухай**

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.5 дахь хэсэг, Дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн ээлжит бус IV хуралдааны 13 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Дүүргийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг 2025 оны 01 дүгээр сарын 02-ны өдөр батлсугай.

2.Батлагдсан төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газар (П.Баттүшиг)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА　　　　　　С.ДАВААСҮРЭН

D:\2025\Zahiramj\Zahiramj.docx

# БАГАНУУР ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН
# ЗАХИРАМЖ

2025 оны 01 сарын 02 өдөр Дугаар А/02 Улаанбаатар хот

Дүүргийн Засаг даргын 2024-2028 оны
үйл ажиллагааны хөтөлбөрийг 2025 онд
хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг
боловсруулах ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.5 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Багануур дүүргийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлагдсантай холбогдуулан хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2025 оны арга хэмжээний төлөвлөгөөний төслийг боловсруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

2.Дүүргийн Засаг даргын 2025 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулахдаа тухайн асуудлын суурь түвшин, хүрэх түвшин, үр дүн болон төсвийг нарийвчлан тооцож, 2025 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн дотор дүүргийн Засаг даргын удирдлагын зөвлөлийн хуралд танилцуулж, батлуулахыг Ажлын хэсэгт даалгасугай.

3.Батлагдсан төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Ажлын хэсэг (П.Баттүшиг)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА С.ДАВААСҮРЭН

D:\2025\Zahiramj\Zahiramj.docx

1225010003

Багануур дүүргийн Засаг даргын 2025
оны .01.. дүгээр сарын .02..-ны өдрийн
..11/02. дугаар захирамжийн хавсралт

## Дүүргийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг 2025 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө боловсруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүн

| | |
|---|---|
| Ажлын хэсгийн ахлагч: | П.Баттүшиг<br>(Засаг даргын Тамгын газрын дарга) |
| Гишүүд: | Б.Бямбацэцэг<br>(Дүүргийн менежер)<br>Б.Туяа<br>(Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга)<br>Н.Оюунцэцэг<br>(Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга)<br>Г.Гэрэлмаа<br>(Засаг даргын Тамгын газрын Нийгмийн хөгжлийн хэлтсийн дарга)<br>Ц.Түвшинжаргал<br>(Засаг даргын Тамгын газрын Архивын хэлтсийн дарга)<br>З.Майдар<br>(Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын дарга, хурандаа)<br>Б.Мөнхчимэг<br>(Засаг даргын Тамгын газрын Тохижилт, нийтийн аж ахуйн хэлтсийн дарга)<br>Б.Анхзаяа<br>(Засаг даргын Тамгын газрын Хүнс, худалдаа үйлчилгээний хэлтсийн ахлах мэргэжилтэн) |
| Нарийн бичгийн дарга: | Ч.Оюун-Эрдэнэ<br>(Засаг даргын Тамгын газрын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний төлөвлөлт, хэрэгжилт хариуцсан ахлах мэргэжилтэн) |

# БАГАНУУР ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН
# ЗАХИРАМЖ

2025 оны 01 сарын 14 өдөр Дугаар А/03 Улаанбаатар хот

**Дүүргийн орон нутгийн хөгжлийн сан болон төсвийн хөрөнгө оруулалтаар худалдан авах ажиллагааг зохион байгуулах тухай**

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.2, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 14.4 дэх хэсэг, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн "Дүүргийн 2025 оны төсөв батлах тухай" ээлжит V дугаар хуралдааны 14 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Дүүргийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө болон төсвийн хөрөнгө оруулалтаар 2025 онд хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг хавсралтаар баталж, уг ажлын худалдан авах ажиллагааг холбогдох хууль журамд нийцүүлэн зохион байгуулж, үр дүнг тайлагнахыг дүүргийн Худалдан авах ажиллагааны алба (О.Мөнхгал)-нд даалгасугай.

2.Энэхүү захирамжийн хавсралтад заасан төсөл арга хэмжээнд захиалагчийн эрхийг хэрэгжүүлэн хяналт тавьж, санхүүжүүлэхэд шаардлагатай хөрөнгийг гүйцэтгэлээр холбогдох хууль журмын дагуу хянан баталгаажуулан олгохыг Засаг даргын Тамгын газар (П.Баттүшиг)-т, санхүүжилтийн эрх нээн төсвийн сар, улирлын хуваарийн дагуу санхүүжүүлэхийг Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Н.Оюунцэцэг)-т, захиалагчийн хяналтыг тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын Тохижилт, нийтийн аж ахуйн хэлтэс (Б.Мөнхчимэг)-т тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА С.ДАВААСҮРЭН

D:\2025\Zahiramj\Zahiramj.docx

1225010038

Багануур дүүргийн Засаг даргын 2025 оны .01.. дүгээр сарын .14...-ны өдрийн .А/03. дугаар захирамжийн хавсралт

Дүүргийн орон нутгийн хөгжлийн сан болон төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний жагсаалт

| № | Төсөл арга хэмжээний нэр, хүчин чадал байршил | Хэрэгжих хугацаа | Батлагдсан төсөвт өртөг (мянга.төг) | 2025 онд санхүүжих (мянга.төг) |
|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 |
| ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САН | | | | |
| Шилжих: | | | | |
| 1 | 2 дугаар хорооны байгууллагуудыг нэгдсэн халаалтын болон цэвэр усны системд холбох | 2022-2024 | 189,998.0 | 31,984.6 |
| 2 | ЭМТ-ийн А, Б блокийн засварын ажил | 2024-2025 | 379,308.8 | 379,308.8 |
| 3 | Гүн галуутай сургуулийн хичээлийн 2 дугаар байрны халаалт, цэвэр бохир усны шугамын засварын ажил | 2024-2025 | 193,029.6 | 193,029.6 |
| 4 | Сургуулийн өмнөх боловсролын байгууллагуудад шаардлагатай гал тогооны болон ахуйн хэрэглээний тоног төхөөрөмж худалдан авах | 2024-2025 | 74,435.0 | 74,435.0 |
| 5 | Шинэ суурьшлын цахилгаан хангамжийн (Талын толгой, Нугын тал, Нарийн нуур, Мэлз) зураг төсөв боловсруулах | 2024-2025 | 45,010.3 | 13,502.8 |
| 6 | ЗДТГ-ын баруун талын соёл амралтын хүрээлэнгийн зураг төсөв боловсруулах | 2024-2025 | 50,835.5 | 50,835.5 |
| Шилжих ОНХС дүн: | | | 932,617.3 | 743,096.4 |
| Шинэ: | | | | |
| Барилга байгууламж 220001 | | | | |
| 7 | Багануур хотын ус хангамжийн шугам сүлжээний өргөтгөл автоматжуулалтын ажил | 2025 | 1,687,473.5 | 1,687,473.5 |
| 8 | Баялаг хороолол 6/0,4кВ-ийн 2х400кВа чадалтай цахилгааны дэд өртөөний барилга | 2025 | 1,331,542.4 | 1,331,542.4 |
| 9 | Багануур дүүргийн зүүн энгэрийн үерийн сувгийн ажил | 2025 | 1,262,779.0 | 1,262,779.0 |
| 10 | 4-р хороонд Спорт урлагийн заалны цогцолбор барилга | 2025-2026 | 3,646,394.8 | 1,940,268.7 |
| ББ дүн: | | | 7,928,189.7 | 6,222,063.6 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| Их засвар 221001 | | | | |
| 11 | Биеийн тамир, спортын хорооны засвар, тохижилтын ажил | 2025 | 619,813.6 | 619,813.6 |
| 12 | Гүн галуутай сургуулийн хичээлийн 1 дүгээр байрны ариун цэврийн өрөөний засварын ажил | 2025 | 385,333.0 | 385,333.0 |
| 13 | 241 дүгээр цэцэрлэгийн хөрсний ус зайлуулах ажил | 2025 | 94,558.8 | 94,558.8 |
| ИЗ дүн: | | | 1,099,705.4 | 1,099,705.4 |
| Зөвлөх үйлчилгээ (Бусад 223001) | | | | |
| 14 | Дахин төлөвлөлт болон хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний зураг хийлгэх | 2025 | 318,800.0 | 318,800.0 |
| 15 | Дахин төлөвлөлттэй холбогдуулан газрыг нэгж талбар бүрээр үнэлэх | 2025 | 172,500.0 | 172,500.0 |
| 16 | Хот суурингийн газрын төлөв байдал чанарын хянан баталгаа хийх | 2025 | 250,000.0 | 250,000.0 |
| ТТ дүн: | | | 741,300.0 | 741,300.0 |
| МТТАТ (70503)83405 | | | | |
| 17 | Тэжээлийн нөөц бүрдүүлэх | 2024-2025 | 40,000.0 | 40,000.0 |
| Шилжих МТТАТ дүн: | | | 40,000.0 | 40,000.0 |
| 18 | Бэлчээрийн менежментийг сайжруулах | 2025 | 20,000.0 | 20,000.0 |
| 19 | Малын эрүүл мэндийг хамгаалах, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх | 2025 | 20,000.0 | 20,000.0 |
| 20 | Тэжээлийн нөөц бүрдүүлэх | 2025 | 67,918.8 | 67,918.8 |
| 21 | Малчдад зориулсан сургалт зохион байгуулах | 2025 | 10,000.0 | 10,000.0 |
| МТТАТ дүн: | | | 117,918.8 | 117,918.8 |
| ОНХС ДҮН: | | | 10,859,731.2 | 8,964,084.2 |
| ДҮҮРГИЙН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ | | | | |
| 1 | Нарийн хэсгийн үерийн хамгаалалтын суваг ус гаргуур-4, гүүр-8, нийт 12 байршил | 2024-2025 | 234,643.4 | 112,044.1 |
| 2 | Хүүхдийн зусланд ариун цэврийн байгууламж | 2024-2025 | 250,000.0 | 250,000.0 |
| 3 | 4-р хорооны барилгын гадна фасад засвар, Иргэдэд үйлчлэх нэг цэгийн дотор засварын ажил | 2024-2025 | 124,089.4 | 124,089.4 |
| 4 | Багануур дүүргийн Уурхайн нийтийн байрны барилгын гадна дулаан, ус хангамжийн шугамын засварын ажил | 2024-2025 | 114,735.0 | 114,735.0 |
| 5 | Д.Нацагдоржийн нэрэмжит номын сангийн засварын ажил | 2023-2025 | 415,383.4 | 415,383.4 |
| 6 | Байдлаг хэсгийн цэцэрлэгт хүрээлэнгийн тохижилт | 2024-2025 | 769,312.3 | 207,089.7 |
| 7 | 3-р хороо Хилчин хэсгийн тохижилт | 2024-2025 | 438,846.6 | 438,846.6 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 8 | Хэрэглээний гадна болон дотор ус дулаан дамжуулах шугам хоолой худалдан авах | 2024-2025 | 197,607.0 | 197,607.7 |
| 9 | Гэр хорооллын гудамжны ус зайлуулах хоолой худалдан авах | 2024-2025 | 79,430.0 | 31,772.0 |
| 10 | Умайн хүзүүний хавдар илрүүлэх "Cerviray AI" төхөөрөмж, дагалдах хэрэгсэл программ хангамжийн эрхийн хамт | 2024-2025 | 28,000.0 | 28,000.0 |
| 11 | Төрийн байгууллагуудад компьютер тоног төхөөрөмж худалдан авах | 2024-2025 | 141,998.0 | 141,998.0 |
| 12 | Спорт хороонд шаардлагатай тоног төхөөрөмж худалдан авах | 2024-2025 | 200,000.0 | 200,000.0 |
| 13 | Ус дулаан дамжуулах төв №10 өргөтгөлийн тоног төхөөрөмж худалдан авах | 2024-2025 | 560,600.0 | 560,600.0 |
| 14 | Цэвэрлэх байгууламжийн агаарын насос худалдан авах | 2024-2025 | 100,000.0 | 100,000.0 |
| 15 | БЦС-ийн хичээлийн 2-р байрны барилгын өргөтгөлийн зураг төсөв боловсруулах | 2024-2025 | 127,000.0 | 127,000.0 |
| 16 | УСБТ-ийн барилгын засварын зураг төсөв боловсруулах | 2024-2025 | 85,500.0 | 85,500.0 |
| 17 | ОБХ-ийн барилга байгууламжийн гадна болон дотор инженерийн шугам сүлжээг засварлах зураг төсөв боловсруулах | 2024-2025 | 19,800.0 | 19,800.0 |
| 18 | 4, 5 дугаар хороонд тохижилт, явган хүний зам, дугуйн замын зураг төсөв боловсруулах | 2024-2025 | 35,000.0 | 35,000.0 |
| 19 | ХЦА-д спорт цогцолборын барилгын зураг төсөв боловсруулах | 2024-2025 | 20,000.0 | 20,000.0 |
| 20 | Авто зам шинээр барих, засвар шинэчлэлтийн зураг төсөв боловсруулах | 2024-2025 | 190,000.0 | 190,000.0 |
| 21 | 4, 5 хорооны цэцэрлэгт хүрээлэнгийн зураг төсөв боловсруулах | 2024-2025 | 50,000.0 | 50,000.0 |
| 22 | Спорт соёл амралтын цогцолборын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөлтийн зураг төсөв боловсруулах | 2024-2025 | 70,000.0 | 70,000.0 |
| 23 | 1-р хорооны нутаг дэвсгэрт дэд бүтээнүүдийн зураг төсөв боловсруулах | 2024-2025 | 200,000.0 | 200,000.0 |
| 24 | Цэцэрлэгт хүрээлэнгийн ариун цэврийн байгууламжийн дулаан ус хангамжийн зураг төсөв боловсруулах | 2024-2025 | 20,000.0 | 20,000.0 |
| 25 | 132 дугаар цэцэрлэгийн өргөтгөлийн холболтын зураг төсөв боловсруулах | 2024-2025 | 50,000.0 | 50,000.0 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 26 | 4-р хороонд спорт, урлагийн заалны цогцолбор барилгын зураг төсөл, төсөв боловсруулах | 2023-2025 | 74,000.0 | 29,600.0 |
| ДТХО ДҮН: | | | 4,595,945.0 | 3,819,065.7 |

**БАГАНУУР ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН**
**ЗАХИРАМЖ**

2025 оны 01 сарын 14 өдөр Дугаар А/04 Улаанбаатар хот

Засварын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог шинэчлэн байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 66.3, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.1 дэх хэсэг, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн "Дүүргийн 2024 оны төсөв батлах тухай" 30 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Эрүүл мэндийн төвийн А, Б блокийн засварын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй шинэчлэн байгуулсугай.

| | |
|---|---|
| Үнэлгээний хорооны ахлагч: | О.Мөнхгал (Худалдан авах ажиллагааны албаны дарга) |
| Гишүүд: | Б.Мөнхчимэг (Засаг даргын Тамгын газрын Тохижилт, нийтийн аж ахуйн хэлтсийн дарга) |
| | Э.Алтангэрэл (Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн мэргэжилтэн) |
| | Б.Эрдэнэбат (Хараат бус хөндлөнгийн үнэлгээний хороо нийгэмд үйлчилдэг төрийн бус байгууллагын гишүүн) |
| Нарийн бичгийн дарга: | П.Амаржаргал (Худалдан авах ажиллагааны албаны мэргэжилтэн) |

2.Техникийн тодорхойлолт бэлтгэх, тендерийн урилга, баримт бичгийг боловсруулах, тендер хүлээн авах, нээх ажиллагааг хуулийн дагуу гүйцэтгэх, хянан үзэх, үнэлэх, үнэлгээний дүгнэлт гаргах, гэрээ байгуулах эрх олгох зөвлөмжийг захиалагчид өгч ажиллахыг Үнэлгээний хороо (О.Мөнхгал)-нд даалгасугай.

3.Энэхүү захирамж гарсантай холбогдуулан дүүргийн Засаг даргын 2024 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн “Засварын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороо байгуулах тухай” А/15 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА С.ДАВААСҮРЭН

**БАГАНУУР ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН**
**ЗАХИРАМЖ**

2025 оны 01 сарын 14 өдөр Дугаар А/05 Улаанбаатар хот

**Төсвийн сар, улирлын хуваарь**
**батлах тухай**

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1.6 дахь заалт, Нийслэлийн Засаг даргын 2025 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн "Төсвийн хуваарь батлах тухай" А/05 дугаар захирамж, Дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн "Дүүргийн 2025 оны төсөв батлах тухай" ээлжит V хуралдааны 14 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Багануур дүүргийн 2025 оны төсвийн орлогын төлөвлөгөөний сар, улирлын хуваарийг нэгдүгээр, дүүргийн 2024 оны зарлага санхүүжилтийн сар, улирлын хуваарийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Батлагдсан төсвийн хуваарийн дагуу санхүүжилтийг хянаж олгохыг Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Н.Оюунцэцэг)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА С.ДАВААСҮРЭН

D:\2025\Zahiramj\Zahiramj.docx
1225010010

**БАГАНУУР ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН**
**ЗАХИРАМЖ**

2025 оны 01 сарын 14 өдөр　　　Дугаар А/06　　　Улаанбаатар хот

U18 насны болон +40 насанд хүрэгчдийн улсын аварга шалгаруулах хоккейн тэмцээнийг зохион байгуулах ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Үндсэн хуулийн 62 дугаар зүйлийн 62.2, Биеийн тамир, спортын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 25 дугаар зүйлийн 25.4 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Монголын хоккейн холбооноос 2025 оны 01 дүгээр сарын 29-31-ний өдрүүдэд U18 насны, 02 дугаар сарын 03-05-ны өдрүүдэд +40 насанд хүрэгчдийн улсын аварга шалгаруулах хоккейн тэмцээнүүдийг тус тус дүүрэгт зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

| | |
|---|---|
| Ажлын хэсгийн ахлагч: | Дүүргийн менежер |
| Гишүүд: | Засаг даргын Тамгын газрын Нийгмийн хөгжлийн хэлтсийн дарга |
| | Засаг даргын Тамгын газрын Хүнс, худалдаа үйлчилгээний хэлтсийн дарга |
| | Засаг даргын Тамгын газрын Тохижилт, нийтийн аж ахуйн хэлтсийн дарга |
| | Цагдаагийн хэлтсийн дарга |
| | Эрүүл мэндийн төвийн дарга |
| | Боловсролын хэлтсийн дарга |
| | Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын хэлтсийн дарга |
| | Соёлын ордны захирал |
| | Багануур тохижилт ААТҮГ-ын захирал |
| | Багануур хоккейн клубын төлөөлөл |
| Нарийн бичгийн дарга: | Биеийн тамир, спортын хорооны дарга |

2.Тэмцээний бэлтгэл ажлыг сайтар хангаж, өндөр түвшинд зохион байгуулахыг Ажлын хэсэгт даалгасугай.

ЗАСАГ ДАРГА　　　С.ДАВААСҮРЭН

D:\2025\Zahiramj\Zahiramj.docx

1225010014

# БАГАНУУР ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 01 сарын 20 өдөр Дугаар А/07 Улаанбаатар хот

## Хурдан морины уралдаан зохион байгуулахыг хориглох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Хүүхдийн эрхийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.2, Хүүхэд хамгааллын тухай хуулийн 27 дугаар зүйл, Засгийн газрын 2019 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн “Хурдан морины уралдааны талаар авах зарим арга хэмжээний тухай” 57 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хурдан морины уралдаанч хүүхдийн амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангах зорилгоор жил бүрийн 11 дүгээр сарын 01-ний өдрөөс 05 дугаар сарын 01-ний өдрийг хүртэлх хугацаанд дүүргийн нутаг дэвсгэрт хурдан морины уралдаан, сунгаа, үсэргээ зохион байгуулахыг хориглосугай.

2.Дүүргийн нутаг дэвсгэрт хурдан морины уралдаан зохион байгуулахгүй байхад хяналт тавьж ажиллахыг Цагдаагийн хэлтэс (Б.Эрдэнэбилэг)-т, хороодын Засаг дарга нарт, захирамжийг иргэд, олон нийтэд сурталчилж ажиллахыг Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын хэлтэс (Т.Хашлянхуа)-т тус тус үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Б.Балжинням)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА С.ДАВААСҮРЭН

D:\2025\Zahiramj\Zahiramj.docx

1225010022

**БАГАНУУР ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН**
**ЗАХИРАМЖ**

2025 оны 01 сарын 24 өдөр　　　Дугаар А/10　　　Улаанбаатар хот

Дүүргийн оны тэргүүний байгууллага,
аж ахуйн нэгж, хүмүүсийг шалгаруулах шалгуур
үзүүлэлтийг шинэчлэн боловсруулах ажлын хэсэг
байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсгийг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Дүүргийн оны тэргүүний байгууллага, аж ахуйн нэгж, хүмүүсийг шалгаруулах шалгуур үзүүлэлтийг шинэчлэн боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

| | |
|---|---|
| Ажлын хэсгийн ахлагч: | П.Баттүшиг<br>(Засаг даргын Тамгын газрын дарга) |
| Гишүүд: | Д.Дэмчигжав<br>(Дүүргийн менежер)<br>Б.Соёл-Эрдэнэ<br>(Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Зохион байгуулалтын хэлтсийн дарга)<br>Б.Туяа<br>(Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга)<br>Н.Оюунцэцэг<br>(Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга)<br>Г.Гэрэлмаа<br>(Засаг даргын Тамгын газрын Нийгмийн хөгжлийн хэлтсийн дарга)<br>Б.Мөнхчимэг<br>(Засаг даргын Тамгын газрын Тохижилт, нийтийн аж ахуйн хэлтсийн дарга)<br>З.Майдар<br>(Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын дарга, хурандаа)<br>Б.Анхзаяа<br>(Засаг даргын Тамгын газрын Хүнс, худалдаа үйлчилгээний даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч) |

Д.Энхбаатар
(1 дүгээр хорооны Засаг дарга)
Ж.Мөнхцэцэг
(2 дугаар хорооны Засаг дарга)
Б.Мөнхнаран
(3 дугаар хорооны Засаг дарга)
Ж.Мөнхцэцэг
(4 дүгээр хорооны Засаг дарга)
Б.Мөнх-Учрал
(5 дугаар хорооны Засаг дарга)

Нарийн бичгийн дарга: Э.Дашхүү
(Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн Хүний нөөц, төрийн албан хаагчийн ёс зүй, шагнал хариуцсан мэргэжилтэн)

2.Дүүргийн оны тэргүүний байгууллага, аж ахуйн нэгж, хүмүүсийг шалгаруулах шалгуур үзүүлэлтийг 2025 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн дотор боловсруулж, Засаг даргын Удирдлагын зөвлөлийн хуралд танилцуулах, энэ оны нэгдүгээр улиралд багтаан дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлаар хэлэлцүүлж, батлуулахыг Ажлын хэсэг (П.Баттүшиг)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА С.ДАВААСҮРЭН

**БАГАНУУР ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН**
**ЗАХИРАМЖ**

2025 оны 01 сарын 29 өдөр  Дугаар А/12  Улаанбаатар хот

Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны
бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 66.3, Хүүхдийн эрхийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.2, Хүүхэд хамгааллын тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.2, 40.3, 40.6, 40.9 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Гэмт хэрэг, зөрчил үйлдсэн гэж сэжиглэгдэн мөрдөн шалгагдаж байгаа, гэмт хэргийн гэрч, хохирогч болсон, ял шийтгүүлсэн, албадлагын арга хэмжээ авагдсан, зөрчил үйлдэж шийтгэгдсэн хүүхдэд үйлчилгээ үзүүлэх Хүүхдийн эрхийн хууль зүйн хороог дараах бүрэлдэхүүнтэй шинэчлэн баталсугай.

| | |
|---|---|
| Хорооны ахлагч: | Засаг даргын орлогч |
| Гишүүд: | Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Нарийн бичгийн дарга бөгөөд Ажлын албаны дарга |
| | Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга |
| | Шүүхийн Тамгын газрын дарга |
| | Прокурорын газрын ерөнхий прокурор, хууль цаазын шадар зөвлөх |
| | Цагдаагийн хэлтсийн дарга |
| | Боловсролын хэлтсийн дарга |
| | Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтсийн дарга |
| | Шүүхийн шийдвэр гүйцэтгэх хэлтсийн дарга |
| | Эрүүл мэндийн төвийн дарга |
| | Дүүргийн хууль зүйн туслалцааны төвийн Улсын өмгөөлөгч |
| Нарийн бичгийн дарга: | Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын хэлтсийн дарга |

2.Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны үйл ажиллагааны төлөвлөгөө, төсвийг хэлэлцүүлэн батлуулж, хэрэгжилтийг ханган тайланг хагас, бүтэн жилээр дүүргийн Хүүхдийн төлөө зөвлөлд тайлагнахыг Хүүхдийн эрхийн хууль зүйн хороонд даалгасугай.

D:\2025\Zahiramj\Zahiramj.docx
1225010033

3.Энэхүү захирамж гарсантай холбогдуулан дүүргийн Засаг даргын 2022 оны 02 дугаар сарын 11-ний өдрийн “Дүүргийн Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай” А/60 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА С.ДАВААСҮРЭН

# БАГАНУУР ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН
# ЗАХИРАМЖ

2025 оны 01 сарын 31 өдөр Дугаар А/15 Улаанбаатар хот

Хүүхдийн төлөө зөвлөлийг шинэчлэн
байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, 66.3, Хүүхдийн эрхийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1, 16.2, 17 дугаар зүйлийн 17.1.1, Хүүхэд хамгааллын тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1, 37.2, 39 дүгээр зүйлийн 39.2.1, 39.2.2, 39.2.3, 39.2.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Дүүргийн Засаг даргын дэргэдэх Хүүхдийн төлөө зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэй шинэчлэн байгуулсугай.

| | |
|---|---|
| Дэд тэргүүн: | Засаг даргын орлогч |
| Гишүүд: | Засаг даргын Тамгын газрын Нийгмийн хөгжлийн хэлтсийн дарга |
| | Цагдаагийн хэлтсийн дарга |
| | Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтсийн дарга |
| | Улсын бүртгэлийн хэлтсийн дарга |
| | Нийгмийн даатгалын газрын дарга |
| | Эрүүл мэндийн төвийн дарга |
| | Боловсрол сургуулийн захирал |
| | Гүн галуутай сургуулийн захирал |
| | Оюуны-Эрин сургуулийн захирал |
| | 1 дүгээр хорооны Засаг дарга |
| | 2 дугаар хорооны Засаг дарга |
| | 3 дугаар хорооны Засаг дарга |
| | 4 дүгээр хорооны Засаг дарга |
| | 5 дугаар хорооны Засаг дарга |
| | Дэлхийн Зөн Олон улсын байгууллагын Багануур орон нутгийн хөтөлбөрийн менежер |
| | Хүүхдийн оролцооны байгууллагын төлөөлөл (2 хүүхэд) |
| Нарийн бичгийн дарга: | Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын хэлтсийн дарга |

2.Хүүхдийн төлөө зөвлөлийн 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг хэлэлцүүлэн батлуулж, төлөвлөгөөний биелэлтийн хэрэгжилтийг ханган ажиллахыг Хүүхдийн төлөө зөвлөлийн Нарийн бичгийн даргад даалгасугай.

D:\2025\Zahiramj\Zahiramj.docx

1225010039

3.Энэхүү захирамж гарсантай холбогдуулан дүүргийн Засаг даргын 2024 оны 02 дугаар сарын 29-ний өдрийн “Дүүргийн Хүүхдийн төлөө зөвлөлийг шинэчлэн байгуулах тухай” А/58 дугаар захирамжийг хүчингүйд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА С.ДАВААСҮРЭН

**БАГАНУУР ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН**
**ЗАХИРАМЖ**

2025 оны 01 сарын 31 өдөр　　　　Дугаар А/16　　　　Улаанбаатар хот

Хэрэглээний гадна болон дотор ус дулаан дамжуулах шугам хоолой хүлээн авах ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэг, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн ээлжит V хуралдааны 14 дүгээр тогтоолын дөрөвдүгээр хавсралтад заагдсан "Дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2024-2025 онд санхүүжүүлэх төсөл арга хэмжээний жагсаалт"-ыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар нийлүүлэх хэрэглээний гадна болон дотор ус дулаан дамжуулах шугам хоолойг хүлээн авах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

| | |
|---|---|
| Ажлын хэсгийн ахлагч: | Б.Мөнхчимэг (Засаг даргын Тамгын газрын Тохижилт, нийтийн аж ахуйн хэлтсийн дарга) |
| Гишүүд: | А.Оюунгэрэл (Засаг даргын Тамгын газрын Тохижилт, нийтийн аж ахуйн хэлтсийн мэргэжилтэн) |
| | Э.Алтангэрэл (Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн мэргэжилтэн) |
| | Л.Ариунжаргал (Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн мэргэжилтэн) |
| | Г.Энхцацрал (Засаг даргын Тамгын газрын Архивын хэлтсийн ажилтан) |
| | Ж.Мөнхцэцэг (Багануур-Ус ААТҮГ-ын ерөнхий инженер) |
| Нарийн бичгийн дарга: | Б.Ганчимэг (Нийлүүлэгч Хүрэн хясаа ХХК-ийн захирал) |

2.Ажлын хэсэгт ажиллахаас өмнө ашиг сонирхлын зөрчилтэй эсэх талаар мэдэгдэл, тайлбар гаргахыг Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд үүрэг болгосугай.

3.Батлагдсан техникийн тодорхойлолт, ажлын тоо хэмжээний дагуу хууль журамд нийцүүлэн хүлээн авч ашиглалтад оруулахыг Ажлын хэсэг (Б.Мөнхчимэг)-т, хөрөнгийг өмчид бүртгүүлэн ажиллахыг Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Н.Оюунцэцэг)-т тус тус даалгасугай.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Дүүргийн менежер (Д.Дэмчигжав)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА С.ДАВААСҮРЭН

# БАГАНУУР ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН
# ЗАХИРАМЖ

2025 оны 01 сарын 31 өдөр　　　　Дугаар А/18　　　　Улаанбаатар хот

Хөрсний ус зайлуулах ажлын гүйцэтгэгчийг
сонгон шалгаруулах үнэлгээний хороог
байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.1 дэх хэсэг, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн "Дүүргийн 2025 оны төсөв батлах тухай" V хуралдааны 14 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Дүүргийн 241 дүгээр цэцэрлэгийн хөрсний ус зайлуулах ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

| | |
|---|---|
| Үнэлгээний хорооны дарга: | О.Мөнхгал (Худалдан авах ажиллагааны албаны дарга) |
| Гишүүд: | Э.Алтангэрэл (Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн мэргэжилтэн) |
| | Ж.Батбаяр (Засаг даргын Тамгын газрын Тохижилт, нийтийн аж ахуйн хэлтсийн мэргэжилтэн) |
| | Ч.Ариунбаатар (Хараат бус хөндлөнгийн үнэлгээний хороо нийгэмд үйлчилдэг төрийн бус байгууллагын гишүүн) |
| Нарийн бичгийн дарга: | П.Амаржаргал (Худалдан авах ажиллагааны албаны мэргэжилтэн) |

2.Техникийн тодорхойлолт бэлтгэх, тендерийн урилга, баримт бичгийг боловсруулах, тендер хүлээн авах, нээх ажиллагааг хуулийн дагуу гүйцэтгэх, хянан үзэх, үнэлэх, үнэлгээний дүгнэлт гаргах, гэрээ байгуулах эрх олгох зөвлөмжийг захиалагчид өгч ажиллахыг Үнэлгээний хороо (О.Мөнхгал)-нд даалгасугай.

ЗАСАГ ДАРГА　　　　С.ДАВААСҮРЭН

D:\2025\Zahiramj\Zahiramj.docx

1225010045

# БАГАНУУР ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН
# ЗАХИРАМЖ

2025 оны 01 сарын 31 өдөр | Дугаар А/19 | Улаанбаатар хот

Барилгын ажлын гүйцэтгэгчийг сонгон
шалгаруулах үнэлгээний хороог байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.1 дэх хэсэг, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн "Дүүргийн 2025 оны төсөв батлах тухай" V хуралдааны 14 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Дүүргийн 4 дүгээр хороонд спорт, урлагийн заалны цогцолборын барилгын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

| | |
|---|---|
| Үнэлгээний хорооны дарга: | О.Мөнхгал (Худалдан авах ажиллагааны албаны дарга) |
| Гишүүд: | Э.Алтангэрэл (Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн мэргэжилтэн)<br>Ж.Батбаяр (Засаг даргын Тамгын газрын Тохижилт, нийтийн аж ахуйн хэлтсийн мэргэжилтэн)<br>Б.Эрдэнэбат (Хараат бус хөндлөнгийн үнэлгээний хороо нийгэмд үйлчилдэг төрийн бус байгууллагын гишүүн) |
| Нарийн бичгийн дарга: | Б.Болорзул (Худалдан авах ажиллагааны албаны мэргэжилтэн) |

2.Техникийн тодорхойлолт бэлтгэх, тендерийн урилга, баримт бичгийг боловсруулах, тендер хүлээн авах, нээх ажиллагааг хуулийн дагуу гүйцэтгэх, хянан үзэх, үнэлэх, үнэлгээний дүгнэлт гаргах, гэрээ байгуулах эрх олгох зөвлөмжийг захиалагчид өгч ажиллахыг Үнэлгээний хороо (О.Мөнхгал)-нд даалгасугай.

ЗАСАГ ДАРГА С.ДАВААСҮРЭН

D:\2025\Zahiramj\Zahiramj.docx

1225010047

# БАГАНУУР ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН
# ЗАХИРАМЖ

2025 оны 01 сарын 31 өдөр　　　Дугаар А/20　　　Улаанбаатар хот

Барааны гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах
үнэлгээний хороог байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.1 дэх хэсэг, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн "Дүүргийн 2025 оны төсөв батлах тухай" V хуралдааны 14 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Тэжээлийн нөөц бүрдүүлэх барааны гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

| | |
|---|---|
| Үнэлгээний хорооны дарга: | О.Мөнхгал (Худалдан авах ажиллагааны албаны дарга) |
| Гишүүд: | Э.Алтангэрэл (Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн мэргэжилтэн) |
| | Ж.Батбаяр (Засаг даргын Тамгын газрын Тохижилт, нийтийн аж ахуйн хэлтсийн мэргэжилтэн) |
| | Ч.Ариунбаатар (Хараат бус хөндлөнгийн үнэлгээний хороо нийгэмд үйлчилдэг төрийн бус байгууллагын гишүүн) |
| Нарийн бичгийн дарга: | Б.Болорзул (Худалдан авах ажиллагааны албаны мэргэжилтэн) |

2.Техникийн тодорхойлолт бэлтгэх, тендерийн урилга, баримт бичгийг боловсруулах, тендер хүлээн авах, нээх ажиллагааг хуулийн дагуу гүйцэтгэх, хянан үзэх, үнэлэх, үнэлгээний дүгнэлт гаргах, гэрээ байгуулах эрх олгох зөвлөмжийг захиалагчид өгч ажиллахыг Үнэлгээний хороо (О.Мөнхгал)-нд даалгасугай.

ЗАСАГ ДАРГА　　　С.ДАВААСҮРЭН

D:\2025\Zahiramj\Zahiramj.docx

1225010049

**БАГАНУУР ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН**
**ЗАХИРАМЖ**

2025 оны 01 сарын 31 өдөр Дугаар А/21 Улаанбаатар хот

Барааны гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах
үнэлгээний хороог шинэчлэн байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 66.3, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.1 дэх хэсэг, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн "Дүүргийн 2025 оны төсөв батлах тухай" V хуралдааны 14 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Өвс тэжээлийн нөөц бүрдүүлэх барааны гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй шинэчлэн байгуулсугай.

| | |
|---|---|
| Үнэлгээний хорооны дарга: | О.Мөнхгал (Худалдан авах ажиллагааны албаны дарга) |
| Гишүүд: | Э.Алтангэрэл (Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн мэргэжилтэн) |
| | Ж.Батбаяр (Засаг даргын Тамгын газрын Тохижилт, нийтийн аж ахуйн хэлтсийн мэргэжилтэн) |
| | А.Эрчис (Хараат бус хөндлөнгийн үнэлгээний хороо нийгэмд үйлчилдэг төрийн бус байгууллагын гишүүн) |
| Нарийн бичгийн дарга: | Т.Баярмаа (Худалдан авах ажиллагааны албаны мэргэжилтэн) |

2.Техникийн тодорхойлолт бэлтгэх, тендерийн урилга, баримт бичгийг боловсруулах, тендер хүлээн авах, нээх ажиллагааг хуулийн дагуу гүйцэтгэх, хянан үзэх, үнэлэх, үнэлгээний дүгнэлт гаргах, гэрээ байгуулах эрх олгох зөвлөмжийг захиалагчид өгч ажиллахыг Үнэлгээний хороо (О.Мөнхгал)-нд даалгасугай.

3.Энэхүү захирамж батлагдсантай холбогдуулан дүүргийн Засаг даргын 2024 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн “Өвс тэжээлийн нөөц бүрдүүлэх худалдан авах барааны гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороо байгуулах тухай” А/03 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА С.ДАВААСҮРЭН

**БАГАНУУР ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН**
**ЗАХИРАМЖ**

2025 оны 01 сарын 31 өдөр Дугаар А/22 Улаанбаатар хот

Газрыг нэгж талбар бүрээр үнэлэх
үйлчилгээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах
үнэлгээний хороог байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.1 дэх хэсэг, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн “Дүүргийн 2025 оны төсөв батлах тухай” V хуралдааны 14 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Дахин төлөвлөлттэй холбогдуулан газрыг нэгж талбар бүрээр үнэлэх үйлчилгээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

| | |
|---|---|
| Үнэлгээний хорооны дарга: | О.Мөнхгал (Худалдан авах ажиллагааны албаны дарга) |
| Гишүүд: | Э.Алтангэрэл (Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн мэргэжилтэн) |
| | Ж.Батбаяр (Засаг даргын Тамгын газрын Тохижилт, нийтийн аж ахуйн хэлтсийн мэргэжилтэн) |
| | Б.Эрдэнэбат (Хараат бус хөндлөнгийн үнэлгээний хороо нийгэмд үйлчилдэг төрийн бус байгууллагын гишүүн) |
| Нарийн бичгийн дарга: | Т.Баярмаа (Худалдан авах ажиллагааны албаны мэргэжилтэн) |

2.Техникийн тодорхойлолт бэлтгэх, тендерийн урилга, баримт бичгийг боловсруулах, тендер хүлээн авах, нээх ажиллагааг хуулийн дагуу гүйцэтгэх, хянан үзэх, үнэлэх, үнэлгээний дүгнэлт гаргах, гэрээ байгуулах эрх олгох зөвлөмжийг захиалагчид өгч ажиллахыг Үнэлгээний хороо (О.Мөнхгал)-нд даалгасугай.

ЗАСАГ ДАРГА С.ДАВААСҮРЭН

D:\2025\Zahiramj\Zahiramj.docx

1225010053

**БАГАНУУР ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН**
**ЗАХИРАМЖ**

2025 оны 01 сарын 31 өдөр Дугаар А/23 Улаанбаатар хот

Зураг хийлгэх үйлчилгээний гүйцэтгэгчийг
сонгон шалгаруулах үнэлгээний хороог байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.1 дэх хэсэг, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн "Дүүргийн 2025 оны төсөв батлах тухай" V хуралдааны 14 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Дахин төлөвлөлт болон хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний зураг хийлгэх үйлчилгээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

| | |
|---|---|
| Үнэлгээний хорооны дарга: | О.Мөнхгал (Худалдан авах ажиллагааны албаны дарга) |
| Гишүүд: | Э.Алтангэрэл (Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн мэргэжилтэн) |
| | Ж.Батбаяр (Засаг даргын Тамгын газрын Тохижилт, нийтийн аж ахуйн хэлтсийн мэргэжилтэн) |
| | А.Эрчис (Хараат бус хөндлөнгийн үнэлгээний хороо нийгэмд үйлчилдэг төрийн бус байгууллагын гишүүн) |
| Нарийн бичгийн дарга: | Т.Баярмаа (Худалдан авах ажиллагааны албаны мэргэжилтэн) |

2.Техникийн тодорхойлолт бэлтгэх, тендерийн урилга, баримт бичгийг боловсруулах, тендер хүлээн авах, нээх ажиллагааг хуулийн дагуу гүйцэтгэх, хянан үзэх, үнэлэх, үнэлгээний дүгнэлт гаргах, гэрээ байгуулах эрх олгох зөвлөмжийг захиалагчид өгч ажиллахыг Үнэлгээний хороо (О.Мөнхгал)-нд даалгасугай.

ЗАСАГ ДАРГА С.ДАВААСҮРЭН

D:\2025\Zahiramj\Zahiramj.docx

1225010055

# БАГАНУУР ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 01 сарын 31 өдөр Дугаар А/24 Улаанбаатар хот

Цахилгааны дэд өртөөний барилгын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.1 дэх хэсэг, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн "Дүүргийн 2025 оны төсөв батлах тухай" V хуралдааны 14 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Баялаг хороололд 6/0,4кВ-ийн 2х400кВ чадалтай цахилгааны дэд өртөөний барилгын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

| | |
|---|---|
| Үнэлгээний хорооны дарга: | О.Мөнхгал (Худалдан авах ажиллагааны албаны дарга) |
| Гишүүд: | Э.Алтангэрэл (Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн мэргэжилтэн) |
| | Ж.Батбаяр (Засаг даргын Тамгын газрын Тохижилт, нийтийн аж ахуйн хэлтсийн мэргэжилтэн) |
| | Б.Эрдэнэбат (Хараат бус хөндлөнгийн үнэлгээний хороо нийгэмд үйлчилдэг төрийн бус байгууллагын гишүүн) |
| Нарийн бичгийн дарга: | Б.Болорзул (Худалдан авах ажиллагааны албаны мэргэжилтэн) |

2.Техникийн тодорхойлолт бэлтгэх, тендерийн урилга, баримт бичгийг боловсруулах, тендер хүлээн авах, нээх ажиллагааг хуулийн дагуу гүйцэтгэх, хянан үзэх, үнэлэх, үнэлгээний дүгнэлт гаргах, гэрээ байгуулах эрх олгох зөвлөмжийг захиалагчид өгч ажиллахыг Үнэлгээний хороо (О.Мөнхгал)-нд даалгасугай.

ЗАСАГ ДАРГА С.ДАВААСҮРЭН

D:\2025\Zahiramj\Zahiramj.docx

1225010057

# БАГАНУУР ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 01 сарын 31 өдөр Дугаар А/25 Улаанбаатар хот

Засвар, тохижилтын ажлын гүйцэтгэгчийг
сонгон шалгаруулах үнэлгээний хороог байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.1 дэх хэсэг, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн "Дүүргийн 2025 оны төсөв батлах тухай" V хуралдааны 14 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Биеийн тамир, спортын хорооны засвар, тохижилтын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

| | |
|---|---|
| Үнэлгээний хорооны дарга: | О.Мөнхгал<br>(Худалдан авах ажиллагааны албаны дарга) |
| Гишүүд: | Э.Алтангэрэл<br>(Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн мэргэжилтэн)<br>Ж.Батбаяр<br>(Засаг даргын Тамгын газрын Тохижилт, нийтийн аж ахуйн хэлтсийн мэргэжилтэн)<br>У.Өсөхбаатар<br>(Хараат бус хөндлөнгийн үнэлгээний хороо нийгэмд үйлчилдэг төрийн бус байгууллагын гишүүн) |
| Нарийн бичгийн дарга: | Б.Болорзул<br>(Худалдан авах ажиллагааны албаны мэргэжилтэн) |

2.Техникийн тодорхойлолт бэлтгэх, тендерийн урилга, баримт бичгийг боловсруулах, тендер хүлээн авах, нээх ажиллагааг хуулийн дагуу гүйцэтгэх, хянан үзэх, үнэлэх, үнэлгээний дүгнэлт гаргах, гэрээ байгуулах эрх олгох зөвлөмжийг захиалагчид өгч ажиллахыг Үнэлгээний хороо (О.Мөнхгал)-нд даалгасугай.

ЗАСАГ ДАРГА С.ДАВААСҮРЭН

D:\2025\Zahiramj\Zahiramj.docx

1225010059